



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

14201 Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, Их сургуулийн гудамж 1,
Утас/Факс: (976-11) 32-06-68
Э-мэйл: news@num.edu.mn
Вэб сайт: www.num.edu.mn

2024.05.14 № 6/1283

танай _____-ны № _____-т

БҮРЭЛДЭХҮҮН СУРГУУЛИЙН ЗАХИРЛУУДАД

МУИС-ийн Ректорын зөвлөлийн 2024 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаанаар 2019 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн А/208 дугаар тушаалаар батлагдсан “МУИС-д профессор багш ажиллуулах журам”-ын холбогдох зарим заалтыг хэрхэн хэрэгжүүлж ажиллахыг хэлэлцэн олонхийн саналаар шийдвэрлэсэн.

Энэхүү шийдвэрийг үндэслэн МУИС-ийн 2024-2025 оны хичээлийн жилийн профессор, дэд профессорын зэрэглэлийн шалгаруулалтын холбогдох зарим заалтын тайлбарыг хавсралтаар хүргүүлж байна.

ХУУЛЬ, ХҮНИЙ НӨӨЦИЙН
БОДЛОГЫН ГАЗРЫН
ДАРГА


Д.ДОЛЖИН

D: 2024 alban bichig A5

1424990981

МУИС-ийн 2024 оны 05 дугаар сарын 14-ний
өдрийн 6/1/283 дугаар албан бичгийн хавсралт



МУИС-ийн 2024-2025 оны хичээлийн жилийн профессор, дэд профессорын зэрэглэлийн шалгаруулалтын холбогдох зарим заалтын тайлбар

МУИС-ийн 2024-2025 оны хичээлийн жилийн профессор, дэд профессорын зэрэглэлд шалгаруулах ажлыг 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 06/1129 тоот албан бичгийн ажлын төлөвлөгөөнд заасан хугацаанд зохион байгуулна.

МУИС-ийн 2024-2025 оны хичээлийн жилийн профессор, дэд профессорын зэрэглэлийн шалгаруулалтыг 2019 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн А/208 дугаар тушаалаар батлагдсан "МУИС-д профессор багш ажиллуулах журам"-ын холбогдох заалтыг мөрдлөг болгон ажиллах бөгөөд энэхүү журмын зарим заалтыг МУИС-ийн Ректоратын зөвлөлийн хурлаар хэлэлцэж олонхийн саналаар шийдвэрлэсэн шийдвэрийг үндэслэн дараах тайлбарын дагуу хэрэгжүүлнэ. Үүнд:

	МУИС-д профессор багш ажиллуулах журмын холбогдох заалт	Тайлбар
1.	Журмын 14.1 дэх заалт: "Бүрэлдэхүүн/салбар сургуулиуд сүүлийн 5 жилд профессор багшийн гүйцэтгэсэн эрдэм шинжилгээний ажлын үзүүлэлтийг гол шалгуур болгон хичээлийн жилийн эцэст дараагийн 3 жилд ажиллах багш нарын албан тушаалын зэрэглэлийг тогтоохдоо үзүүлэлт бүрийг хэрхэн хангасан байдлыг холбогдох нотлох баримт, тайлбарын хамт бүрдүүлж, бүрэлдэхүүн/салбар сургуулийн захирлын тушаалаар томилогдсон, ашиг сонирхлын зөрчилгүй, тухайн нэгжид харьяалалгүй төлөөлөл бүхий үнэлгээний хороогоор үнэлүүлж, захиргааны зөвлөлөөр хэлэлцүүлэн шийдвэрээ МУИС-ийн үнэлгээний хороонд 06-р сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ. Урт хугацааны томилолтоор ажиллаж буй багш нь үнэлгээний хугацаанд зэрэглэлд тавигдах шаардлага хэрхэн хангасан тухай холбогдох баримт, тайлбарыг үнэлгээний хооронд ирүүлж үнэлгээнд заавал орно. Холбогдох хугацаанд үнэлгээнд ороогүй багш нь томилолтоос эргэн ирэх үед тухайн нэгжид байгаа сул орон тоонд ажиллах бөгөөд уг орон тооны зэрэглэлийн шаардлагыг хангасан байх шаардлагатай."	<ol style="list-style-type: none">1. Тухайн зэрэглэлд 3 жил ажилласан нийт профессор, дэд профессор нь профессор, дэд профессорын зэрэглэлийн шалгаруулалтад орно.2. Профессор, дэд профессор цол авсан бол харгалзах албан тушаалын зэрэглэлд шалгаруулаггүй ажиллана.3. Ахлах багшийн зэрэглэлд 1 жил ажилласан докторын зэрэгтэй багш дэд профессорын зэрэглэлийн шалгаруулалтад орж болно.4. Тухайн багшийн профессор, дэд профессорын зэрэглэлд ажилласан жил нь 3 жил хүрээгүй тохиолдолд шалгаруулалтад орохгүй.5. Урт хугацааны чөлөөтэй багш нь шалгаруулалтад орно.

2	<p>Журмын 8.3 дахь заалт: “Тухайн мэргэжлийн салбарт ажиллаж байгаа эрдмийн зэрэгтэй багш нарын тоонд нийт профессорын боломжит орон тоог харгалзуулж, түүний дотор профессор, дэд профессорын зэрэглэлийн харьцаа 1:3-аас хэтрэхгүй байна. МУИС-ийн профессор цол хүртсэн багш нарыг энэхүү харьцаанд оруулж тооцохгүй.” Журмын 8.4 дэх заалт: “Энэхүү харьцааг бүрэлдэхүүн/салбар сургууль бүрд үндсэн орон тоогоор ажиллаж байгаа эрдмийн зэрэгтэй багшийн тоогоор тогтоох бөгөөд шинжлэх ухааны тодорхой нэг чиглэлээр эрдмийн зэрэгтэй 4-өөс доошгүй багш байгаа нөхцөлд нэг нь профессор байх боломж бүрдэнэ. Шинжлэх ухааны чиглэл хооронд профессорын орон тоог шилжүүлэхгүй.”</p>	<p>1. “Тухайн мэргэжлийн салбар, шинжлэх ухааны тодорхой нэг чиглэл” гэдгийг тухайн мэргэжлийн тэнхим гэсэн агуулгаар ойлгоно.</p> <p>2. Орон тоо тогтоосон харьцаа нь бутархай тоо гарсан тохиолдолд бүхэл орноор тооцох ба бутархайн орон 0,5 ба түүнээс дээш тохиолдолд өсгөж тооцно.</p> <p>3. МУИС-ийн профессор цол авсан багшийг орон тооны 1:3 харьцаанд оруулж тооцохгүй.</p> <p>4. Удирдах албан тушаал хашиж буй багшийг орон тооны 1:3 харьцаанд оруулж тооцохгүй.</p>
3	<p>Журмын 14.3 дахь заалт: “Профессорын зэрэглэлийн нэг орон тоонд уг болзлыг хангасан хэд хэдэн багш байх тохиолдолд олон улсын сэтгүүлд хэвлүүлсэн өгүүллийн тоо, түүнд зохиогчийн оруулсан хувь нэмэр, монограф бүтээл удирдан хэрэгжүүлсэн судалгааны төсөл зэрэг үзүүлэлтийг харгалзан хавсралт 1 /хүснэгт 2/-д заасны дагуу оноогоор шалгаруулна.”</p>	<p>1. Шалгаруулалтад орсон профессорын материалыг үнэлэхдээ оноо өгч үнэлэхгүй.</p> <p>2. Профессорын зэрэглэлийн шаардлагыг хангасан хэд хэдэн багш байх тохиолдолд /хавсралт1/-ын хүснэгт 2-д заасан оноо өгч, үнэлж шалгаруулна.</p>